



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/280

Улаанбаатар хот

Г МУИС-д суралцагч суралцуулах гэрээ батлах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайдын 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26 дугаар тушаалын хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын 2.1.7, МУИС-ийн Дүрмийн 4.3.1 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцагч суралцуулах гэрээг 1 дүгээр хавсралтаар, Ахисан түвшний хөтөлбөрт суралцагч суралцуулах гэрээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн батлагдсан гэрээний дагуу суралцагчидтай шинэчлэн гэрээ байгуулж ажиллахыг Ахисан түвшний сургуулийн захирал (Н.Баатарбилэг), Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Хишигням), Бүрэлдэхүүн сургуулийн захирал (Д.Заяабаатар, Ч.Энхбаяр, Ж.Баттогох, Б.Амарсанаа, Д.Бямбажав) нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахисан түвшний сургуулийн захирал (Н.Баатарбилэг), Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Хишигням) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/350 дугаар тушаалаар батлагдсан “МУИС-д оюутан суралцуулах гэрээ”, 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан “МУИС-ийн Ахисан түвшинд суралцагч суралцуулах гэрээ”-г тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

1422062163

Захирлын 2022 оны 11 дугаар сарын 05 -ны
өдрийн 11 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

11/280

1117144746
УЧИЛГАЛЫН ТУШААЛЫН НОМРЭЛ

**МУИС-ИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ
СУРАЛЦАГЧ СУРАЛЦУУЛАХ ГЭРЭЭ**

№

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Нэг талаас МУИС (цаашид "Сургууль" гэх), түүнийг төлөөлж Сургуулийн захирал , нэгээ талаас овогтой (цаашид "Суралцагч" гэх), овогтой (цаашид суралцагчийн эцэг, эх/асран хамгаалагч /аль нь болохыг доогуур зурах/ гэх) (хамтад нь "Талууд" гэх) нар МУИС-ийн Бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийн дагуу суралцагч сурах, суралцуулах, сургах талаар харилцан зөвшөөрч энэхүү гэрээг байгуулав.

1.2 Суралцагч, түүний эцэг, эх/асран хамгаалагч нь "МУИС-ийн Сургалтын хөтөлбөрийн журам", "МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журам"-ыг уншиж танилцан, сайн дурын үндсэн дээр суралцагч тус сургуульд суралцахаар харилцан тохиролцсон болно.

1.3 Сургалтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах зорилгоор Монгол Улсын хэмжээнд дээд боловсролын сургалтын бодлого, хэрэгжилтийг зохицуулах, холбогдох удирдамжаар хангах эрх үүрэг бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан сургуулийн дүрэм, журам шинэчлэгдэх ба түүнийг талууд дагаж мөрдөнө.

ХОЁР. Суралцагчийн эрх, үүрэг

2.1 Суралцагч дараах эрхтэй:

- 2.1.1 МУИС-ийн бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийн дагуу суралцах;
- 2.1.2 Суралцах нөхцөл бололцоогоор хангасан эрүүл, аюулгүй орчинд суралцах;
- 2.1.3 Зохих шалгуур хангасан суралцагч Боловсролын зээлийн сангийн зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын байгууллага, сан, хувь хүн болон МУИС-ийн нэрэмжит тэтгэлэгт өрсөлдөх;
- 2.1.4 Хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлтэй эдлэх;
- 2.1.5 Сургууль, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах, шүүмжлэх, шаардлага тавих;
- 2.1.6 МУИС-ийн дүрэм, журамд заасан эрх эдлэх;

2.2 Суралцагч дараах үүрэгтэй:

- 2.2.1 МУИС-ийн дүрэм, журмыг чанд мөрдөх;
- 2.2.2 Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших;
- 2.2.3 Амжилттай суралцахын тулд өөрөөс шалтгаалах бүхий л хүчин чармайлт гаргаж, бие даан суралцах арга барилыг эзэмших;
- 2.2.4 МУИС-ийн нэр хүндийг ямагт хүндэтгэх, багш, ажилтан, бусад суралцагчдад хүндэтгэлтэй, ёс зүйтэй харилцах;
- 2.2.5 МУИС-ийн Удирдах зөвлөлийн тогтоосон сургалтын төлбөрийг заасан хугацаанд төлөх;
- 2.2.6 Эрүүл мэндийн албан журмын даатгалд даатгуулах;
- 2.2.7 Сургалт, судалгаа, хүмүүжилтэй холбоотой сургуулиас зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох;
- 2.2.8 Суралцагч өөрийн болон эцэг эх, асран хамгаалагчийн холбогдох цахим шуудан, утасны дугаар, гэрийн хаяг өөрчлөгдсөн бол өөрчлөлтийг бүртгүүлэх;

ГУРАВ. Суралцагчийн эцэг, эх/асран хамгаалагчийн эрх, үүрэг

- 3.1 Суралцагчийн эцэг, эх/асран хамгаалагч дараах эрхтэй:
 - 3.1.1 Суралцах үйл ажиллагааны үйл явц, үр дүнтэй танилцах;
 - 3.1.2 Суралцагчийн сургалтын мэдээллийг холбогдох журмын дагуу сургалт хариуцах нэгжээс авах хүсэлт гаргах;
 - 3.1.3 Сургуулийн сургалтын орчин, чанар, багшийн үйл ажиллагаатай холбогдсон санал, хүсэлт гаргах;
- 3.2 Суралцагчийн эцэг, эх/асран хамгаалагч дараах үүрэгтэй:
 - 3.2.1 Суралцагчийн эцэг, эх/асран хамгаалагчийн холбогдох цахим шуудан, утасны дугаар, гэрийн хаягт өөрчлөлт орох бүрт сургуульд мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүйн улмаас холбоо тасарсан тохиолдолд сургууль хариуцлага хүлээхгүй.
 - 3.2.2 Эрүүл мэндийн албан журмын даатгалд суралцагчийг даатгуулах;
 - 3.2.3 Суралцагчийг боловсрол эзэмшихэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

ДӨРӨВ. Сургуулийн эрх, үүрэг

- 4.1 Сургууль дараах эрхтэй:
 - 4.1.1 МУИС-ийн Удирдах зөвлөлөөс баталсан хичээлийн багц цагийн сургалтын төлбөрийн хэмжээг суралцагчид мэдээлж, сургалтын төлбөрийг нэхэмжилж авах, сургуулиас нэхэмжилж буй төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх;
 - 4.1.2 Суралцагч сургалтын төлбөрийн үлдэгдэлтэй тохиолдолд төгсөлтийн болон бусад бичиг баримтыг гаргахгүй, хүлээлгэн өгөхгүй байх;
 - 4.1.3 Суралцагчийн дараах хувийн мэдээллийг бүртгэж, суралцах хугацаанд сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл боловсруулах, сургалтын явцын талаар эцэг (эх), асран хамгаалагчид мэдээлэл өгөх, тушаал шийдвэр, тодорхойлолт гаргах, боловсролын асуудал эрхэлсэн болон бусад төрийн захиргааны төв байгууллагын системд бүртгэж статистик мэдээ, тайлан гаргах зэрэгт бүртгэн цуглуулах, боловсруулах, ашиглах. Үүнд:
 - 4.1.3.1 Суралцагчийн ургийн овог
 - 4.1.3.2 Эцэг (эх), асран хамгаалагчийн овог нэр
 - 4.1.3.3 Эцэг эх, асран хамгаалагчийн ажлын газар
 - 4.1.3.4 Эцэг эх, асран хамгаалагчийн утасны дугаар
 - 4.1.3.5 Эцэг эх, асран хамгаалагчийн цахим шуудангийн хаяг
 - 4.1.3.6 Суралцагчийн өөрийн нэр
 - 4.1.3.7 Хүйс
 - 4.1.3.8 Иргэншил
 - 4.1.3.9 Төрсөн он сар өдөр, төрсөн газар
 - 4.1.3.10 Оршин суугаа газрын хаяг, байршил, утасны дугаар
 - 4.1.3.11 Регистрийн дугаар
 - 4.1.3.12 Боловсрол
 - 4.1.3.13 Сургуулийн албан хэрэгцээнд ашиглах зорилгоор фото зураг, дүрс бичлэг авах
 - 4.1.3.14 Цахим тодорхойлогч зэрэг
 - 4.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн мэдээллийг бүртгэж, суралцах хугацаанд шаардлагатай тохируулга хийх, тэтгэлэг олгох, буцалтгүй тусламжид хамруулах, сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл боловсруулах, сургалтын явцын талаар эцэг (эх), асран хамгаалагчид мэдээлэл өгөх, тушаал шийдвэр гаргах, боловсролын асуудал эрхэлсэн болон бусад төрийн захиргааны төв байгууллагын

- системд бүртгэж статистик мэдээ, тайлан гаргах зорилгоор цуглуулах, боловсруулах, ашиглах;
- 4.1.5 Суралцагчийн талаарх 4.1.3, 4.1.4-д дурдсан хүний хувийн болон тусгай мэдээллийг тэтгэлэг олгох, уралдаан, тэмцээнд оролцох, зээл, буцалтгуй тусlamжид хамрагдах зэрэг үйл ажиллагааны үед холбогдох эрх бүхий байгууллагуудад дамжуулах;
- 4.1.6 Сургуулиас гарсан, шилжсэн, суралцах үйл ажиллагаа дуусгавар болсон ч сургуулийн дотоодын болон гэрээт ажил олгогч байгууллага холбогдох эрх бүхий байгууллагад мэдээллийг илгээх зорилгоор суралцах хугацаанд бий болсон болон төгсөлттэй холбоотой хувийн мэдээллийг бүртгэн цуглуулах, хадгалах, боловсруулан ашиглах. Үүнд:
- 4.1.6.1 Дипломын дугаар захиалах
- 4.1.6.2 Диплом, дүнгийн хавсралт хэвлэх, системд архивлах
- 4.1.6.3 Тушаал, шийдвэр гаргах
- 4.1.6.4 МУИС-ийн мэдээллийн систем, архив, цахим хуудсанд хадгалах, байршуулах
- 4.1.6.5 Дээд боловсролын мэдээллийн системд оруулах
- 4.1.6.6 Төгсөгчдөд төгссөн тухай тодорхойлолт, диплом хавсралтыг дахин олгох
- 4.1.6.7 Гэрээт ажил олгогч байгууллагад төгсөгчдийн мэдээллийг илгээх
- 4.1.6.8 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын системд бүртгэж статистик мэдээ, тайлан гаргах
- 4.1.6.9 Сургуулийн албан хэрэгцээнд ашиглах зорилгоор фото зураг, дүрс бичлэг авах зэрэг
- 4.1.7 Суралцагчийг дараах шалтгаанаар бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн шийдвэрийг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасна. Үүнд:
- 4.1.7.1 4 улирал сургалтад оролцоогүй;
- 4.1.7.2 3 улирал дараалан 0.7-оос доош голч дүнтэй суралцсан;
- 4.1.7.3 Хөтөлбөр сонголт хийлгүйгээр Ерөнхий суурин хөтөлбөрт 4 улирал ба түүнээс дээш хугацаагаар суралцсан;
- 4.1.7.4 Эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаа үнэлүүлэхдээ хуурч мэхэлсэн нь тогтоогдсон;
- 4.1.7.5 Бусдад санаатайгаар хуулуулсан;
- 4.1.7.6 МУИС-д ашиглагддаг мэдээллийн системд өөрт нь олгосон эрхээс бусад байдлаар ашигласан нь тогтоогдсон, тухайн үйлдлийн хүрээнд мэдээллийг санаатай өөрчилсөн, өөрчлөхийг оролдсон, устгасан нь тогтоогдсон;
- 4.1.7.7 МУИС-ийн баримт бичиг (диплом, дипломын хавсралт, дүнгийн тодорхойлолт гэх мэт) хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон;
- 4.1.7.8 Ёс зүйн ноцтой зөрчил гаргасан нь МУИС-ийн ёс зүйн маргаан таслах бүрэлдэхүүний хурлын шийдвэрээр тогтоогдсон;
- 4.1.8 Суралцагч 4.1.7-д заасан шалтгаанаар хасагдсан тохиолдолд сургалтын төлбөр буцаан олгохгүй.
- 4.2 Сургууль дараах үүрэгтэй:
- 4.2.1 Суралцагчийг дээд боловсролтой иргэн болгох, хөдөлмөрийн зах зээлд мэргэжлийн түвшинд ажиллахад шаардагдах тодорхой шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшүүлэх, МУИС-ийн бакалаврын түвшний батлагдсан хөтөлбөрөөр суралцуулах;
- 4.2.2 Мэргэжлийн багшлах боловсон хүчинээр хангах;
- 4.2.3 Суралцах хугацаанд сурх орчин нэхцэл, хичээлийн байр, сургалт явуулахад зайлшгүй шаардагдах сургалтын багаж хэрэгсэл, материалаар хангах;

- 4.2.4 Суралцагчийн сургалтын явцын талаар эцэг, эхэд нь жилд нэг удаа цахим шуудангаар мэдээлэх ба мэдээлэл авах боломжоор хангах;
- 4.2.5 Хөгжлийн бэрхшээлтэй оюутны бие эрхтэн, хөгжлийн онцлогийг хүндэтгэн үзэж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдын адил тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх;
- 4.2.6 Суралцагчийн сургууль болон багштай холбоотой гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх, хариу өгөх;
- 4.2.7 Суралцагчийг суралцах хугацаанд сургуулийн орчинд бие маход, сэтгэл санаа, бэлгийн дарамтад өртөхгүй байхад анхаарах, хэрэв өртсөн тохиолдолд таслан зогсох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх;
- 4.2.8 Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, давагдашгүй хүчин зүйлийн улмаас сургуулийн хэвийн үйл ажиллагаа түр зогсох тохиолдолд гарсан шийдвэрийг суралцагч, түүний эцэг, эх/асран хамгаалагч наарт мэдэгдэнэ.

ТАВ. Бусад

5.1. Энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбоотой гарсан маргааныг талууд сургуулийн дүрэм, журмын дагуу эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Зөвшшилцөлд эс хүрвэл маргааныг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5.2. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, оюутан сургуулиас чөлөөлөгдөх, хасагдах, төгсөх тойрох хуудсыг тушааж, тооцоо нийлснээр гэрээ дуусгавар болно.

Гэрээ байгуулсан:

Сургуулийг төлөөлж:

Бүрэлдэхүүн Сургуулийн захирал

Гарын үсэг

Овог нэр:

Огноо:

Утасны дугаар:

Цахим хаяг:

Суралцагч:

Бүрэлдэхүүн Сургууль

Гарын үсэг

Овог нэр:

Огноо:

Утасны дугаар:

Цахим хаяг:

Гэрийн хаяг:

Эцэг, эх/асран хамгаалагчийг төлөөлж:

Овог нэр:

Гарын үсэг

Огноо:

Утасны дугаар:

Цахим хаяг:

Гэрийн хаяг:

Гэрээг хүлээн авсан:

Элсэлт, бүртгэлийн хэлтэс

..... /албан тушаал/

..... /овог нэр/

..... /гарын үсэг/

..... /огноо/